



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот


**Төрийн алба хаасан хугацааны  
нэмэгдэл олгох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, 57.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.5, 4.10.6 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт, Даргын дэргэдэх зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь

1. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн С.Туяа-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг 2020 оны 05 сарын 11 ны өдрөөс тооцон нөхөн олгосугай.
2. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцож холбогдох журмын дагуу бодож 1149721 төгрөг олгохыг нягтлан бодогч /Г.Баярмаа/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /З.Зулгэрэл /-д үүрэг болгосугай.

Хавсралт ..... хуудастай

**ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



**Ц.ЦОГТГЭРЭЛ**

215030023

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛЫН  
ХҮРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021.02.01

Улаанбаатар хот



№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	ХУГАЦАА	ХАРИУЦАХ АЛБАН ТҮШААЛТАН
1	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хушцацаны нэмэгдэл олгох тухай	2 цаг	Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн 3.Зүлгэрэл

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
ХУУЛЬ, ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

3.ЗҮЛГЭРЭЛ

**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН  
ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдааныг газрын даргаар удирдуулан 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 10:40 цагт газрын даргын өрөөнд хуралдав.

Хуралдаанд:

Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Цогтгэрэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн С.Туяа, Эдийн засагч Н.Буянхишиг, Нягтлан бодогч Г.Баярмаа, Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн З.Зулгэрэл нар оролцов.

**Хэлэлцэх асуудал:**

1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай

**Хэлэлцсэн нь:**

**Газрын дарга Ц.Цогтгэрэл:** Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн албаны тухай шинэчилсэн хуульд төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай болон албан хаагч С.Туяагийн хүсэлтийн дагуу энэ асуудлыг хэлэлцэж байна.

Төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан албан тушаалын сарын үндсэн цалингаас Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу олгож байгаа тиймээс Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн албан хаагчдын төрийн албанд ажилласан хугацааг нотлох баримтын дагуу тооцож судалгааг гаргаж олгох тушаалыг гаргаж танилцуулах шаардлагатай.

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмын болзол хангаж байгаа нийт 5 албан хаагчдад олгож байгаа одоо нэмээд 2 албан хаагчдад нэмэгдэл олгох нь зүйтэй гэж үзэж байна, та бүхэн саналаа хэлнэ үү.

**Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн С.Туяа:** Миний бие нь 1990 оноос эхлэн Төрийн байгууллагад ажиллаж, Чингэлтэй дүүрэгт 2000 оноос эхлэн тасралтгүй 20 жил ажилласан. Төрийн захиргааны албан тушаалаас Төрийн улс төрийн албан тушаалд, Төрийн албанд нийт 22,5 жил ажилласан. Төрийн улс төрийн ангилалаас төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон тухайн үед хуульд өөрчлөлт орж төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасны нэмэгдэл олгох тухай сайн ойлголт байгаагүй тул 2020 оны төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл мөнгийг олгож өгнө үү. Төрийн байгууллагад ажиллаж байгаа бүх ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаалуудыг Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэнд өгч хувийн хэрэгт хийсэн байгаа.

**Нягтлан бодогч Г.Баярмаа:** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох болзолыг хангаж байгаа албан хаагчдын холбогдох материалыг шалгаж олгоход татгалзах зүйл байхгүй.

**Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн 3.Зулгэрэл:** Байгууллагын хэмжээнд төрийн албанд ажилласан хугацааны судалгааг хүн тус бүрээр гаргасан. Нэмэгдэл олгох нийт 7 албан хаагч байна. Одоогийн байдлаар 17,2 жил ажилласан Ж.Баяндаваа, 17,7 сар ажилласан Б.Дэжээхүү, 14,4 сар ажилласан С.Энхбаатар, 13 жил ажилласан Г.Баярмаа, 5,4 сар ажилласан А.Билимгүл нарт нэмэгдэл олгож байна, нэмэгдээд 5 жил ажилласан Ц.Цогтгэрэл 60 сар ажиллаад 2021 оны 01 дүгээр сараас 61 дэх сар нь гүйцэж байгаа тул нэмэгдэл олгох эрх үүссэн.

Мөн С.Туяа нь тус байгууллагад 2020 оны 04 сарын 08-ны өдөр түр томилогдож жинхлэн томилогдсон, 2020 оны 05 дугаар сараас эхлэн Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох эрх үүссэн тул нэмэгдлийг олгох нь зүйтэй.

**Газрын дарга Ц.Цогтгэрэл:** 5 нэмэгдэл авч байгаа албан хаагч нар дээр нэмэгдэж байгаа С.Туяад нэмэгдэл олгож болох уу?

**Нягтлан бодогч Г.Баярмаа:** С.Туяагийн хувьд Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл авах эрх нь үүссэн, Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтын дагуу олгож болно.

**Газрын дарга Ц.Цогтгэрэл:** С.Туяад нэмэгдэл олгох асуудал болон нэр бүхий албан хаагч нарт үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгохыг дэмжиж байгаа гишүүд саналаа хэлнэ үү.

*/Санал хураалт олонхийн саналаар 100 хувь дэмжигдэв/*

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Хяналт- шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн С.Туяагийн 2021 оны 5 сараас хойш нэмэгдэл нөхөж олгох тушаал, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл авах албан хаагчдын жагсаалтыг гаргаж, холбогдох журмын дагуу олгохыг Нягтлан бодогч /Г.Баярмаа/-д даалгаж шийдвэрлэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА

Ц.ЦОГТГЭРЭЛ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХУУЛЬ, ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

3.ЗУЛГЭРЭЛ

ГИШҮҮД:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

С.ТУЯА

НЯГТЛАН БОДОГЧ

Г.БАЯРМАА

ЭДИЙН ЗАСАГЧ

Н.БУЯНХИШИГ